



## БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: БУА-2024/089/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:  
[www.open.audit.mn](http://www.open.audit.mn)

Булган аймаг  
2025 он

Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд  
Тэргүүлэх аудитор: Ж.Энхцоодол  
Утас: 7034-2580 Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитын менежер: Ж.Энхцоодол  
Цахим хаяг: [enkhtsoodolj@audit.gov.mn](mailto:enkhtsoodolj@audit.gov.mn)

Аудитор: Г.Цэрэнлхам  
Цахим хаяг: [Tserenlhamg@audit.gov.mn](mailto:Tserenlhamg@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	18
5.1 Төлбөрийн акт .....	18
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	18
5.2 Албан шаардлага .....	18
5.3 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	20

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУ	Монгол Улс
ЗГ	Засгийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл

**Нэг. Хараат бус аудиторын дүгнэлт /Баталгаажсан хувийг оруулах/**



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,  
63082, Утас/Факс: 7034-2580  
Цахим шуудан: bulgan@audit.gov.mn

2024.02.24 № 281  
танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

БУЛГАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА  
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ДАРГА Ү.БЯМБАСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган аймгийн Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Аудитын гол асуудал**

Нэмэлт санхүүжилтийн төсвийг зарцуулах төсвийн эрх нээлгэхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангиллыг баримтлаагүй, тайлант хугацааны санхүүгийн үр дүнгийн тайлангийн зардлыг

632502541

бодит гүйцэтгэлээр илэрхийлээгүй, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас цалин, томилолт, шатахуунд зориулалт бусаар зарцуулсан байна.

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 65 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилтийг аймгийн Засаг даргын 2024 оны А/794 дүгээр тушаалаар 97.5 хувьтай үнэлүүлэн "маш сайн" үнэлгээ авсан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захиаргчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Ж.ЭНХЦООДОЛ

**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

(мянган төгрөг)

	Үзүүлэлт	2023.12.31	2024.12.31.
<b>Санхүүгийн байдлын тайлан</b>			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	164,806.0	123,360.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	493,421.6	664,981.0
	<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>658,227.6</b>	<b>788,341.6</b>
	Нийт өр төлбөрийн дүн	-	84.0
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	658,227.6	788,257.6
	<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>658,227.6</b>	<b>788,341.6</b>
<b>Санхүүгийн үр дүнгийн тайлан</b>			
	Үйл ажиллагааны орлогын дүн	1,196,431.3	1,655,668.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	1,116,566.9	1,525,638.9
	<b>Үйл ажиллагааны үр дүн</b>	<b>79,864.4</b>	<b>130,030.0</b>
	Үйл ажиллагааны бус үр дүн	(716.7)	-
	<b>Үйл ажиллагааны нийт үр дүн</b>	<b>79,147.7</b>	<b>130,030.0</b>
<b>Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан</b>			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	579,079.9	658,227.6
	Тайлант оны үр дүн	79,147.7	130,030.0
	<b>Эцсийн үлдэгдэл</b>	<b>658,227.6</b>	<b>788,257.6</b>
<b>Мөнгөн гүйлгээний тайлан</b>			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	1,067,941.3	1,516,517.4
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	1,036,960.2	1,413,800.2
	<b>Үйл ажиллагааны ЦМГ</b>	<b>30,981.1</b>	<b>102,717.2</b>
	<b>Хөрөнгө оруулалтын ЦМГ</b>	<b>(30,981.1)</b>	<b>(102,717.2)</b>
	<b>Санхүүгийн ажиллагааны ЦМГ</b>	-	-
	<b>Нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
<b>Төсвийн гүйцэтгэлийн тайлан</b>			
	<b>Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн</b>	<b>873,603.6</b>	<b>1,152,799.1</b>
	Урсгал зардал	873,603.6	1,152,799.1
	Хөрөнгийн зардал	-	-
	<b>Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр</b>	<b>873,603.6</b>	<b>1,152,799.1</b>
	Улсын төсвөөс санхүүжих	806,830.5	1,057,825.6
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	66,773.1	94,973.5

## **Гурав. Аудитын илрүүлэлт:**

Аудитаар нийт 204,951.6 мянган төгрөгийн 1 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 204,951.6 мянган төгрөгийн 1 алдааг залрууллаа. Үүнд:

- Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийн баталгаа, бараа материал, Үндсэн хөрөнгийн данс тус бүрээр тооцоо бодсон актыг дутуу ирүүлсэн, төсвийн гүйцэтгэлийн тайланд 204,951.6 мянган төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг зардлаар тайлагнасан, санхүүгийн тайлангийн иж бүрдлийг хангуулаагүй байна.

Аудитаар залруулагдаагүй 11,044.8 мянган төгрөгийн 2 зөрчилд 2 зөвлөмж ажиллалаа.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 5,703.7 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө.

### **5.1 Төлбөрийн акт**

Төлбөрийн акт тогтоогдоогүй.

### **5.2 Албан шаардлага**

1. Өмнөх оны сүүлийн хагас жилийн үр дүнгийн урамшууллыг тайлант оны батлагдсан төсвөөс хэтрүүлэн олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.2 дахь заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, Төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.5 дахь заалтыг үндэслэн зөрчлийг таслан зогсоох, дахин давтан гаргахгүй байх албан шаардлага тогтоолоо.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Зардалтай холбоотой асуудал**

*Илрүүлэлт:* Нэмэлт санхүүжилтийн данснаас бараа үйлчилгээний бусад зардал (210801), бусад бараа үйлчилгээний зардлаас (210901) зардлаас цалин, томилолт, шатахуун, холбооны зардалд 9,287.8 мянган төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын “Зардлын эдийн засгийн ангилал батлах тухай” 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан журам, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Өгсөн зөвлөмж: Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулах эрх нээлгэхдээ зардлын эдийн ангиллын дагуу эрх нээлгэж, зарцуулж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	(мянган төгрөгөөр)									
	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийг зардлаар тайлагнасан, Санхүүгийн тайлангийн иж бүрдлийг хангуулаагүй.	1	204,951.6			1	204,951.6				
Дүн	1	204,951.6		-	1	204,951.6				-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	(мянган төгрөгөөр)											
	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нэмэлт санхүүжилтийн данснаас бараа үйлчилгээний бусад зардал (210801), бусад бараа үйлчилгээний зардлаас (210901) зардлаас цалин, томилолт, шатахуун, холбооны зардалд зарцуулсан.	1	9,287.8										

Өмнөх оны сүүлийн хагас жилийн үр дүнгийн урамшууллыг тайлант оны батлагдсан төсвөөс зориулалт бусаар олгосон.	1				1	1,757.0							
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>11,044.8</b>			<b>1</b>	<b>1,757.0</b>	<b>1</b>	<b>9,287.8</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>-</b>

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

(мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>								
Дүн								
<b>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил /төрийн хэмнэлтийн тухай хууль/</b>								
Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн, шилэн дансанд мэдээлсэн мэдээллийн нотлох баримтыг хавсралт файл хэсэг оруулах мэдээлэл байхгүй төлөвөөр мэдээлсэн.	1	-			1	-		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН  
ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 02/112

Булган сум

А0670253 040-2025/089/НА-СТА-ТМС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлж, давтан тооцоолол хийхэд Геодизи зураг зүйн ерөнхий газрын даргын тушаалаар даргын 2023 оны сүүлийн хагас жилийн үр дүнгийн урамшууллыг тайлант оны батлагдсан төсвөөс олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4, Засгийн газрын 2019 оны Засгийн газрын тухай хуулийн 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2.1-д "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид" гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.5-т "Төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1.Зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх.

2.Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), нягтлан бодогч (П.Шүрэнцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН  
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

АУДИТОР

ЖЭНХЦООДОЛ

Г.ЦЭРЭНЛХАМ

117144798  
ГС/А0848 3190269

632504385



БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН  
ШААРДЛАГА

2025 оны 02 дугаар сарын 24

Дугаар 01/111

Булган сум

АДБТ0253

БҮА-2025/089/НА-СТА-ТМБ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аймгийн Булган аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроож мэдээлсэн, шилэн дансанд мэдээлсэн мэдээллийн нотлох баримтыг хавсралт файл хэсэг оруулах мэдээлэл байхгүй төлөвөөр мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-т "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ийн 6.3-т "Шилэн дансны тухай хуулийн 7.1-д заасан дараах албан тушаалтан шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу оруулах үүрэгтэй" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хугацаанд нь иж бүрэн мэдээлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн дотор Булган аймаг дахь Төрийн аудитын газар-т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн), нягтлан бодогч (П.Шүрэнцэцэг) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН АЛБАН  
ТУШААЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТОР

Г.ЦЭРЭНЛХАМ

632504387